



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 0/136

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиглах үйлчилгээний болон тусгай хэрэгцээний автомашины тоо, төрлийг тогтоох санал боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Должинсорогдог (аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Г.Базар (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)

П.Галсандорж (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Х.Цэнд-Аюуш (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Баярмаа (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Х.Амаржаргал (аймгийн Эрүүл мэндийн газрын Хөрөнгө оруулалт, дотоод аудит хариуцсан нягтлан бодогч)

Ц.Бэхбаяр (аймгийн Соёл, урлагийн газрын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга)

Б.Батжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга)

Х.Буянтогтох (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, орон нутгийн өмч, жижиг, дунд үйлдвэрлэл, хоршооны бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн)

А.Энхжаргал (аймгийн Орон нутгийн өмчийн газрын нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ч.Лхагвамядаг (аймгийн Орон нутгийн өмчийн газрын Боловсрол, соёлын байгууллагын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн)

2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиглах үйлчилгээний болон тусгай хэрэгцээний автомашины тоо, төрлийг хуулийн этгээдийн байршил, үйл

d/zahiramj

671 0103 18

ажиллагааны онцлог, цар хүрээ зэргийг харгалзан тогтоож, саналыг 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Должинсорогдог)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР